УБДС ХК
Улаанбаатар хот
Баянгол дүүрэг
Энгельсийн гудамж
Утас: 11-343030, 11-342397
Факс: 11-342397
Web:http://www.ubds.energy.mn

0265. Хавдарт өвчин судлалын үндэсний төв

**УЛААНБААТАР**
**ДУЛААНЫ СҮЛЖЭЭ ХК**

# ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧИЙГ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

**УЛААНБААТАР ХОТ**

БАТЛАВ.
УЛААНБААТАР ДУЛААНЫ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ХАЙДАВ
..........................................
/Гарын үсэг, тамга/

БАТЛАВ.
халдварт өвчин судлалын
үндэсний төв
захирал
............................ /Д.Нямхүү/
/Гарын үсэг, тамга/

## ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧИЙГ ХУДАЛДАХ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2014 оны 09 сарын 05-ны өдөр № 0265 Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас УБДС ТӨХК-ийг төлөөлж Дулааны үйлчилгээний 2 /дүгээр/, /дугаар/ салбарын дарга Л. Амарбат /цаашид худалдагч гэх/, нөгөө талаас халдварт өвчин судлалын үндэсний төв ХХК-г төлөөлж захирал албан тушаалтай ............................ /цаашид худалдан авагч гэх/ нар Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг тус тус үндэслэл болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

1.2. Энэхүү гэрээгээр дулааны эрчим хүчийг гэрээнд заасан тоо, чанарын түвшинд худалдах /халаалт, хэрэглээний халуун ус, салхивч болон технологийн халуун ус/ эрчим хүч хэрэглэсний төлбөрөө тогтоосон хугацаанд бүрэн төлөх, талууд харилцан эрх эдлэж, үүрэг хүлээх, хариуцлага хүлээлгэх, хэрэглэгчийг эрчим хүчээр хангахтай холбоотойгоор хангагч талаас тавих технологийн горимтой холбоотой шаардлагыг хэрэглэгч тал ханган биелүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.